



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/02

ӨВТ

Шуурхай бүлэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчний голомтод ажиллах шуурхай бүлгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Шуурхай бүлгийн дарга: Л.Батчулуун (Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад)

Х.Цэдэндорж (Эрүүл мэндийн төвийн дарга)

Р.Даваасүрэн (Хөдөө аж ахуйн тасгийн тархвар зүйч)

Б.Батбилэгт (“Хустын рашиаан” Мал эмнэлгийн эзэн)

П.Содномбалжир (“Хутагт уулын өгөөж” Мал эмнэлгийн малын эмч)

Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Г.Сугар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Н.Түвшин (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Х.Чулуунбат (Байгаль хамгаалагч)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

И.Маралмаа (Газрын даамал)

Ц.Бадрал (Холбоо мэдээлэл хариуцсан туслах)

Багийн Засаг дарга нар

2. Малын гоц халдварт шүлхий өвчний оношийг баталгаажуулах хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журмыг мөрдөж, шүлхий өвчний нөхцөл байдлын талаар тухай бүр мэдээлж ажиллахыг Шуурхай бүлгийн дарга (Л.Батчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



051101003

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/